

**Удирдах ажилтнуудын 09 дүгээр сарын 02-ны өдрийн  
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлт**

2019 оны 9 дүгээр сарын 16

№	Өгөгдсөн үүрэг, даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	Золбин нохой устгах	9 дүгээр сард	Сумдын ЗДТГ	Шивээговь – Золбин нохой, муур устгалын ажлыг ОНХСангийн 1,2 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгүүлэхээр УБ хотын иргэнтэй гэрээ байгуулсан ба 30 гаруй нохой устгаад байна.	Хэрэгжилт ийг тооцох хугацаа болоогүй
2	Иргэдэд үйлчлэх төвөөр үйлчилгээ үзүүлэх цагийн хуваарийг гаргаж Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлэх	2019 оны 09 дүгээр сарын 4	Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө, аж ахуйн газар	6 байгууллага хуваарь гаргаж ирүүлэхээс Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Сүмбэр сумын ЗДТГ хуваарийг ирүүлж, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс ирүүлээгүй.	30
3	Иргэдэд үйлчлэх төвд холбогдох мэргэжилтнүүдийг 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн цагийн хуваарийн дагуу тогтмол ажиллуулж, тайланг сар бүрийн 25-ны өдрийн дотор Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлж байх	2019 оны 09 дүгээр сарын 4	Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө, аж ахуйн газар	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс хоёроос бусад байгууллага Иргэдэд үйлчлэх төвд мэргэжилтнээ ажиллуулаагүй байна.	30

4	Чинээлэг малчин төслийн талаар танилцуулах	2019 оны 09 сард	ХААГ, МАГ, хуулийн байгууллагууд	“Чинээлэг малчин” төслөөс малчдад тараасан хуц, ухнын талаарх мэдээлэл, жагсаалтыг холбогдох байгууллагаас авч, тараасан хуц, ухныг ангилан ялгах ажлыг гүйцэтгэж байна.	Хэрэгжилт ийг тооцох хугацаа болоогүй
5	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөө батлуулах /Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэнэ./	2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор	Бүх байгууллагууд	АЗДТГ, Нэгдсэн эмнэлэг, Сүмбэр сумын ЗДТГ, Nes oil ШТС, ХХҮГазар, Мал эмнэлгийн газар, Боржигин өв музей, Дугуй дэлгүүр, 1 дүгээр цэцэрлэг, ГХБХБГазар гэсэн 10 байгууллага төлөвлөгөөгөө батлуулаад байна.	30
6	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлын төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох ажил, үүргийг хэрэгжүүлэн ажиллах.		Бүх байгууллагууд	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлын төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох ажил, үүргийг хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна. Цаашид эрчимжүүлэх шаардлагатай	0
7	Жагсаалын нэгдсэн бэлтгэл, жигдрэлтийн сургууль хийх тул алба хаагч нараа бүрэн хамруулах./Баяр наадмын талбай/	2019 оны 9 дүгээр сарын 06, 13, 20, 27, 10 дугаар сарын 04-ний өдрүүдэд	Бүх байгууллагууд	2019.09.06-ны өдрийн сургуулилтанд 980 албан хаагч оролцохоос 50 байгууллагын 662 хүн оролцсон. Цагдаагийн хэлтэс, Шивээ овоо ХК, Боржигин чуулга ирц бүрэн, Аймгийн онцгой комисс, Төмөр зам, ШТС-ууд, Дугуй дэлгүүр, Үүрэн холбооны газрууд, ШША-ны ирц цөөн байсан бол Статитисктийн хэлтэс, Татварын хэлтэс, Аудитын газар, НДХ, Андууд худалдааны төв, Дашваанжил, Горгаз, Баяннексус ХХК-ийн албан хаагчид оролцоогүй.	70
8	Үер уснаас урьдчилан сэргийлэх самбараа байршуулах	2019 оны 09 сард	Сумдын Засаг дарга нар	Шивээговь сумын ЗДТГазар 1, Сүмбэр сумын ЗДТГазар 2 самбар хийж байршуулсан.	Хэрэгжилт ийг тооцох хугацаа болоогүй
9	ГХИБС-ийн бэлтгэл ажлын хүрээнд сургалтын хуваарь батлагдсан тул дээрх сургалтад ажилтан, алба хаагчдаа бүрэн хамруулах. /хуваарийг <a href="http://go.nema.gov.mn/">http://go.nema.gov.mn/</a> вэб хаягт байршуулах болно	Тухай бүрд	Бүх байгууллагууд	ГХИБСургалтыг хуваарийн дагуу 4 удаа 127 хүнд зохион байгуулаад байна. Үүнд: Сүмбэр сумын ЗДТГ – 1 удаа 24 хүн Боловсролын байгууллагууд – 1 удаа 38 хүн Иргэд – 2 удаа 65 хүн	100
10	Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын болон Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-н үйл ажиллагаатай танилцах, өвөлжилтийн бэлтгэл ажил хангуулах,	2019 оны 09 дүгээр сарын 10-ны дотор	ТЗУХ, ХЭЗХ, ХОХБТХ	Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-ын өвөлжилтийн бэлтгэл ажилтай 09 дүгээр сарын 02-ны өдөр танилцаж, 09 дүгээр 10-ны дотор дуусгах үүрэг даалгавар өгсөн.  Өнөөдрийн байдлаар 1, 2, 3-р зуухны засвар болон цахилгааны мантаж засварын ажлууд 90 хувьтай, 3-р	70

				байрны шугам засварын ажил 90 хувьтай, үнс буулгах талбай, нүүрс татан авалт, барилгын засварын ажлууд хийгдээгүй байна. Өвөлжилтийн бэлтгэл ажил 80 хувьтай хийгдэж байна.	
11	Сүмбэр сумын худалдан авах ажиллагаанд хяналт тавих, шалгалт хийх	2019 оны 09 сард	ХОХБТХ	Сүмбэр сумын худалдан авах ажиллагаанд хяналт хийсэн. Нийт 8 бараа, ажил үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулахаас 2 ажил үлдсэн бөгөөд Сүмбэр сумын 1-р багийн байруудын дээвэр засварын ажлыг 9 дүгээр сарын 11-ний өдөр зарласан, 18-ны өдөр нээнэ. Зураг төсвийн ажил гэрээ шууд байгуулахаар төлөвлөсөн, гэрээ байгуулагдаагүй байна.	70
12	Эйкүсори компанийн үйл ажиллагааг зогсоох	2019 оны 09 сард	МХГ, БОАЖГ, хуулийн байгууллагууд	МХГ- Эйкү сора ХХК-д 2019.09.11-нд шалгалтад хамрагдахыг мэдэгдсэн ч тус компанийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ажлын хэсэг байгуулагдан уулзалт нь 2019.09.11-ний өдөр товлогдсон тул шалгалтыг хойшлуулах хүсэлтийг ирүүлсэн. Иймд шалгалтад хамрагдтал үйл ажиллагаа явуулахгүй байхыг мэдэгдсэн.	Хэрэгжилт ийг тооцох хугацаа болоогүй
13	Төсвийн байгууллагуудад халаалт өгөх өдрийг товлох, аймгийн нэгдсэн эмнэлгийн халаалтыг эрт өгөх асуудлыг шийдвэрлэх	2019 оны 09 сарын 15	ХОХБТХ болон бүх байгууллагууд	2019-2020 оны төвлөрсөн халаалтыг 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлүүлэхээр аймгийн Засаг даргын захирамжийг гаргуулж, байгууллагуудад хүргүүлэхээр ажиллаж байна.	30
14	<b>Биелэлтийн дундаж хувь</b>				<b>47,8</b>

## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС